

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гучин-Ус сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2024/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Арвайхээр хот 2023 он	Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn Аудитор: Э.Энхбаяр Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn
------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гандангийн гудамж,
5 дугаар баг, Арлайхаар сум, Өвөрхангай аймаг, 52173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим илүүдэл: ovorkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2024.05.25 № 144
танай _____-ны № _____ -1

ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГА
Х.ЭНХТАЙВАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Гучин-Ус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гучин-Ус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Гучин-Ус сумын ТТЗ-ын 2023 оны төсвийн татварын орлогыг 171.2 сая төгрөг, татварын бус орлогыг 68.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 51.3 хувь буюу 245.8 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Харин сумын ТТЗ-ийн төсвийн зарлагын хэмжээг 1,917.2 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны гүйцэтгэлээс 184.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

015001716

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О БАТЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	781,286.1	602,049.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,994,037.1	2,203,120.5
	Нийт хөрөнгийн дүн	2,775,323.2	2,805,169.8
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,775,323.2	2,805,169.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,775,323.2	2,805,169.8
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,805,072.1	1,574,687.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,117,545.9	1,365,793.9
	Үйл ажиллагааны үр дүн	687,526.2	208,893.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	3,701,633.5	215,146.6
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(3,013,917.2)	(6,253.4)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	810,965.7	810,965.7
	Тайлант оны үр дүн	(3,013,917,191.4)	(6,253,391.6)
	Эцсийн үлдэгдэл	2,775,323,225.3	2,805,169,833.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,495,163.0	1,468,068.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,954,459.3	1,218,017.3
	Үйл ажиллагааны ЦМГ	540,703.7	250,051.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(222,756.3)	(369,761.6)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(92,536.2)	(78,242.8)
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	225,411.3	(197,952.9)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	187,893.5	413,304.7
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	413,304.7	215,351.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,273,651.8	1,599,718.9
	Урсгал зардал	967,799.4	1,302,167.0
	Хөрөнгийн зардал	213,316.3	219,309.069
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,229,759.5	1,704,413.9
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	961,800.2	1,297,267.0
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	155,444.6	236,338.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	83,424.8	140,186.8
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,089.7	30,622.0
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 1 зөрчил илэрч, 1 албан шаардлага хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй

3.2 Албан шаардлага

1. Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 44.8 хувь буюу 47.1 сая төгрөгийг дутуу төвлөрүүлснээс ОНХС-гийн 6 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 41 дүгээр зүйлийн 41.1-д “Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ.”, 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон орлогыг бүрэн төвлөрүүлэх”, 41.2.7-д “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Малын тоо, толгойн албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дүн	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Гучин-Ус сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0	0	0	0	0
Дүн	1	0	0	0	1	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн	0	0	0	0	0	0	0	0
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	НИЙТ	1	1				1		

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6217143681
ИЮА0059 9044094